



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

XXI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 20:00 цагт Онцгой байдлын ерөнхий газрын “Соёмбо” танхимаас 93 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,*

2. “Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл

*Шуурхай штабын дарга, хурандаа  
Ц.Ганзориг,*

3. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян нарт:*

1.1. Засгийн газрын 2021 оны 154 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 31 хоногоор сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

1.2. Засгийн газрын 2021 оны 155 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор авто замын болон төмөр замын боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 31 хоногоор сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

*Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах нарт:*

2.1. Хүн амын хөл хөдөлгөөн их хэмжээгээр нэмэгдэж коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт цаашид нэмэгдэх хандлагатай байгаа тул мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн халдвар тархах өндөр эрсдэл бүхий чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, саун, бассейны үйл ажиллагааг 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаатай үйл ажиллагааг нь зогсоох.

2.2. Үйл ажиллагааг нь нээсэн худалдаа, үйлчилгээний салбаруудын цагийн хуваарьт хязгаарлалт, зохицуулалт хийж халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч, хатуу хяналт тавьж ажиллах /хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг заалаар үйлчлэхийг хориглосон хугацааг 10 хоногоор сунгах, амралт, жуулчны баазын үйл ажиллагааг хязгаарласан хугацааг 10 хоногоор сунгах/;

2.3. Худалдаа, үйлчилгээний салбарууд хууль, журамд заасан шаардлага, халдвар хамгааллын дэглэм мөрдөж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих, зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагууд хуульд заасан арга хэмжээ авч, халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;

2.4. Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын халдваргүйжүүлэлтийн ажилд хяналт тавьж ажиллах;

*Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт:*

3.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг илүү сайжруулах, эмнэлзүйн багийн үйл

ажиллагааг эрчимжүүлж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн, гарсан үр дүнгийн талаар Улсын онцгой комисст 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор танилцуулах;

3.2. Гэрээр тусгаарлагдан эмчлэгдэж байгаа коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эм, эмийн хэрэгслийн хангалтыг тасралтгүй нийлүүлж, хэрэглээнд хяналт тавих;

3.3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдолдлыг тусгаарлан эмчлэх байр, эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх цэгийг боломжит байршилд нээж ажиллуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

*Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг нарт:*

4.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт, эрэмблэн ангилалт, шаардлагатай эмчилгээний талаарх зөвлөмж зөвлөгөө, мэдээ, мэдээллийг боломжит бүх сувгаар иргэд, олон нийтэд тогтмол хүргэх;

4.2. Улсын хэмжээнд 12-17 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг вакцинжуулах ажлыг аюулгүй, өргөн хүрээнд зохион байгуулж, эцэг эхчүүдийг хүүхдээ вакцинд эрчимтэй хамруулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөвлөмж, мэдээлэл тогтмол хүргэж ажиллах;

4.3. Вакцинд хамруулах шинжилгээний цэг, цэгүүдийн байршлыг тодорхой болгож хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулах;

4.4. Мутацилагдсан вирусын талаар хийж байгаа судалгааны ажил, гадаад улс оронд шинжлүүлэхээр явуулсан сорьцын шинжилгээний явц, үр дүнгийн талаар Улсын онцгой комиссын ээлжит хуралдаанд танилцуулах;

4.5. Эрчимт эмчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй 24 цагийн үйл ажиллагаатай шуурхай багийг Эрүүл мэндийн сайдаар ахлуулан байгуулж Улсын онцгой комиссын Шуурхай штабын дэргэд ажиллуулах, хүндрэл, нас баралтаас сэргийлэх бүхий л нөөц боломжийг дайчлан ажиллах;

*Тав. Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт:*

5.1. “Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, дүгнэлтийг тусган нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах;

*Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт:*

6.1. Эмч, эмнэлгийн ажилтан, гамшгийн үед дайчлагдан ажиллаж байгаа резидент эмч, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн оюутнууд, хувийн хэвшлийн эмч, эмнэлгийн ажилтнуудын судалгааг гаргаж, тэдгээрт цалин урамшуулал, илүү цагийн хөлс олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;

*Долоо. Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:*

7.1. “119” дуудлагын төвийг үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах ажлын хүрээнд оператор компаниудтай яаралтай гэрээ байгуулах;

*Найм. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбатад:*

8.1. Монгол Улсын Засгийн газрын 118 дугаар тогтоолоор батлагдсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын хэрэгжилтийг хангаж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын 30 хүртэл хувийг ажиллуулж, бусдыг зайнаас ажиллах шаардлагыг хэрэгжүүлэх.

*Ес. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Шадар сайдын Ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Ц.Уртнасан нарт:*

9.1. “Эрдэнэт” ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар барьж “Эрдэнэт-Медипас” ХХК-д үнэ төлбөргүй шилжүүлсэн эмнэлгийг хуулийн дагуу төрийн өмчид буцаан авч цар тахлын үед ашиглах, түүнтэй холбоотой цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулах,

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ